ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорноговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/21/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг Сайншанд сум)

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@ audit.gov.mn

Аудитор: Б.Отгон-Өлзий

Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ 3

2 Аудитын тайлан 5

2.1 Оршил ..... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 7

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 7

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... 9

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....

2.11. Шилэн дансны мэдээлэл .....

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....

3 Менежментийн захидал

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан 13

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 №1-6/135

танай________-ны №__________-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
СҮРЭН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Д.Сүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2020 оны 01 сарын 27-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 17 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын эрхэм зорилго нь “Эко системийн даацад тохируулан тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа хүчин чармайлтыг өрнүүлэх замаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн байгаль орчны хамгааллын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний амьдрах, хөдөлмөрлөх, байгаль орчны таатамжтай нөхцөлийг бүрдүүлэх
- Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого боловсруулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийн халдашгүй байдлыг хангах

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 417,647.0 мянган төгрөгөөс тооцон *8,352.9* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,315.5 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 2507.0 | 2007.0 | -500.0 |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 4,319.7 | 8,601.8 | 4,282.1 |
| Үндсэн хөрөнгө | 289,279.8 | 291,683.5 | 2,403,7 |
| **Нийт хөрөнгө** | 151,090.1 | 140,774.6 | -10,315.5 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 151,090.1 | 140,774.6 | -10,315.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 151,090.1 | 140,774.6 | -10,315.5 |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь.бичиг хэргийн материалын дансны үлдэгдэл 176.5 мянган төгрөг, аж ахуйн материалын үлдэгдэл 3226.2 мянган төгрөг, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 1,120.0 мянган төгрөгөөр тус тус өсч, түлш, шатах тослох материалын үлдэгдэл 240.6 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Бараа материалын үлдэгдлүүд бүгд ашиглагдаж байгаа буюу ашиглагдах шаардлага хангасан материалууд байна. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тоног төхөөрөмж 2,403.7 мянган төгрөгөөр худалдан авснаас шалтгаалжээ.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тайлант орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч гүйцэтгэлээр 700.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Усны шинжилгээний дүгнэлтийн хураамж | 0.0 | 700.0 | -700.0 | |
| **Нийт дүн** | 0.0 | 700.0 | -700.0 | |

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орлого 700.0 мянган төгрөг нь усны шинжилгээний дүгнэлтийн хураамжийн орлого төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 404,721.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 404,721.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 404,721.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нийт урсгал зардлын төсвийн зардлын гүйцэтгэлийг 01 хувь буюу 350.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь орлого 700.0 мянган төгрөг оруулж, улсын төсөвт 2,886.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

**Нэмэлт төсөв:** Урьд оны үлдэгдлээс 2,506.9 мянган төгрөгийн орлого, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2260.0 мянган төгрөгийн нийт 4766.9 мянган төгрөгөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,200.0 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 500.0 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын зардалд 60.0 мянган төгрөг нийт 2,760.0 мянган төгрөг зарцуулж 2,007.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 1 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж, нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 1,426.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлийг хянах шаардлагатай.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 90 мэдээллийг хугацаанд нь, 57 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,286.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтооснoос 1,000.0 мянган төгрөгийг барагдуулсан байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

. Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын -ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн байна. Тухайлбал: 670.0 мянган төгрөгийн үнэтэй гар утас, 230.0 мянган төгрөгийн үнэтэй ус цэвэршүүлэгчийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна.
2. Аж ахуйн материалын дансанд бичиг хэрэг, тусгай зориулалтын материалд хүнсний материалыг бүртгэсэн, нээлттэй хаалганы өдрөөр авто машины түрээсийн зардал 526.0 мянган төгрөгийг материалын дансанд орлого, зардлаар бүртгэсэн байна.

3. **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**3.1 Балансын данстай холбоотой асуудал**

3.1.1 Илрүүлэлт:
Бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь үнэ зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Бараа материалыг дансны ангиллын дагуу тайлагнаагүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны нэгдсэн зааврын дагуу бүртгэх, шууд зардлыг холбогдох дансдад бүртгэж тайлагнах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**3.2 Балансын данстай холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 900.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байна. Энэ нь үнэн зөв байх, үнэлгээ, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгө шамшигдах эрсдэлтэй

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Дээр дурдсан 900.0 мянган төгрөгийн үнэтэй, 2 ширхэг үндсэн хөрөнгийг материалын данснаас шилжүүлж үндсэн хөрөнгөнд бүртгэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудит газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,826,628.00** | **10,608,728.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,506,960.00 | 2,006,960.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,506,960.00 | 2,006,960.00 |
| **3121** | **Төгрөг** | 2,506,960.00 | 2,006,960.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 2,506,960.00 | 2,006,960.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,319,668.00 | 8,601,768.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,319,668.00 | 8,601,768.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 796,650.00 | 973,150.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,831,418.00 | 5,057,618.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 1,120,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,691,600.00 | 1,451,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **144,263,459.13** | **130,165,913.82** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 144,263,459.13 | 130,165,913.82 |
| **392** | **Биет хөрөнгө** | 53,415,459.13 | 39,317,913.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,935,093.70 | 9,935,093.70 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -900,000.00 | -1,473,344.88 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 69,625,720.00 | 69,625,720.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -62,847,962.20 | -67,449,143.80 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 80,592,970.48 | 82,996,670.48 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -61,942,831.60 | -68,228,708.32 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,109,791.00 | 12,109,791.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,044,624.92 | -8,121,224.70 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 25,968,230.00 | 25,968,230.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -12,080,927.33 | -16,045,169.66 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 90,848,000.00 | 90,848,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 90,848,000.00 | 90,848,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **151,090,087.13** | **140,774,641.82** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **151,090,087.13** | **140,774,641.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 151,090,087.13 | 140,774,641.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 208,125,647.48 | 208,125,647.48 |
| 51101 | Өмч: - төрийн | 208,125,647.48 | 208,125,647.48 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -61,298,209.77 | -71,613,655.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -61,298,209.77 | -61,298,209.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -10,315,445.31 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,262,649.42 | 4,262,649.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **151,090,087.13** | **140,774,641.82** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **417,798,081.00** | **407,331,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,835,481.00** | **2,960,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,835,481.00 | 2,960,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,360,000.00 | 2,960,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,360,000.00 | 2,960,000.00 |
| 120009 | Бусад орлого | 1,475,481.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **404,962,600.00** | **404,371,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 402,775,100.00 | 404,371,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 402,775,100.00 | 404,371,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,187,500.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,187,500.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **425,254,333.06** | **417,647,045.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **425,254,333.06** | **417,647,045.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 398,425,713.70 | 413,260,122.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 143,630,419.00 | 124,525,475.56 |
| 210101 | Үндсэн цалин | 137,687,327.00 | 113,622,975.56 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 10,902,500.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,943,092.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,294,727.64 | 15,953,471.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,798,120.00 | 11,069,667.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,501,593.00 | 1,245,275.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,120,496.00 | 995,943.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 366,121.00 | 248,770.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,508,397.64 | 2,393,816.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,610,176.00 | 4,178,724.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 716,716.00 | 497,992.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,240,466.00 | 3,210,389.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 652,994.00 | 470,343.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,650,162.00 | 10,179,153.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,381,882.00 | 737,414.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,468,000.00 | 8,071,466.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,395,500.00 | 913,268.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 126,200.00 | 126,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 278,580.00 | 330,805.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 494,500.00 | 495,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 494,500.00 | 495,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,955,160.00 | 938,450.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 417,560.00 | 214,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,537,600.00 | 724,350.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,478,500.00 | 3,509,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,478,500.00 | 3,509,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36,420,560.00 | 191,269,470.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,898,000.00 | 189,735,960.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 178,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 337,950.00 | 350,340.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,610.00 | 126,370.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 54,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 800,000.00 | 801,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 180,891,509.06 | 62,211,379.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 162,154,966.00 | 44,970,134.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 740,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,436,543.06 | 16,501,245.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,828,619.36 | 4,386,922.44 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 26,828,619.36 | 2,886,922.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,828,619.36 | 2,886,922.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-7,456,252.06** | **-10,315,445.31** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,600,805.24 | 00.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 1,600,805.24 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,600,805.24 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-9,057,057.30** | **-10,315,445.31** |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **419,077,560.00** | **407,331,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,114,960.00** | **2,960,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 14,114,960.00 | 2,960,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 11,360,000.00 | 2,960,000.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,360,000.00 | 2,960,000.00 |
| 120009 | Бусад орлого | 2,754,960.00 | 00.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **404,962,600.00** | **404,371,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 402,775,100.00 | 404,371,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 402,775,100.00 | 404,371,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,187,500.00 | 00.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **409,167,460.00** | **405,427,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **409,167,460.00** | **405,427,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **382,338,840.64** | **401,040,977.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 143,630,419.00 | 124,525,475.56 |
| 210101 | Үндсэн цалин | 130,838,528.00 | 113,622,975.56 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 10,902,500.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,791,891.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,822,727.64 | 15,953,471.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,326,120.00 | 11,069,667.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,501,593.00 | 1,245,275.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,179,858.00 | 995,943.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 306,759.00 | 248,770.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,508,397.64 | 2,393,816.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,610,176.00 | 4,178,724.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 716,716.00 | 497,992.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,240,466.00 | 3,210,389.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 652,994.00 | 470,343.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,013,890.00 | 10,149,787.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,208,740.00 | 638,314.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,951,600.00 | 8,150,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,414,100.00 | 913,268.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 126,200.00 | 126,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 313,250.00 | 322,005.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 484,500.00 | 495,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 484,500.00 | 495,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,463,160.00 | 1,428,450.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 417,560.00 | 414,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,045,600.00 | 954,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,478,500.00 | 3,509,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,478,500.00 | 3,509,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36,420,560.00 | 196,347,870.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,898,000.00 | 194,814,360.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 178,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 337,950.00 | 350,340.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,610.00 | 126,370.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 54,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 800,000.00 | 801,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 163,414,908.00 | 44,453,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,114,908.00 | 43,713,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 740,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,828,619.36** | **4,386,922.44** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 26,828,619.36 | 2,886,922.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,910,100.00** | **1,903,700.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,403,140.00** | **2,403,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,403,140.00** | **2,403,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,403,140.00 | 2,403,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,403,140.00 | 2,403,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,403,140.00** | **-2,403,700.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,506,960.00 | -500,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 2,506,960.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,506,960.00 | 2,006,960.00 |

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд сан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 117,277,647.48 | 296,296.67 | -52,241,152.47 | 65,332,791.68 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **117,277,647.48** | **296,296.67** | **-52,241,152.47** | 65,332,791.68 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -9,057,057.30 | -9,057,057.30 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,125,647.48** | **4,262,649.42** | **-61,298,209.77** | 151,090,087.13 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,125,647.48** | **4,262,649.42** | **-61,298,209.77** | 151,090,087.13 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **208,125,647.48** | **4,262,649.42** | **-61,298,209.77** | 151,090,087.13 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -10,315,445.31 | -10,315,445.31 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,125,647.48** | **4,262,649.42** | **-71,613,655.08** | 140,774,641.82 |

## 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 413,935,100.00 | 389,741,980.04 | 404,721,600.00 | 405,071,600.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 413,935,100.00 | 389,741,980.04 | 404,721,600.00 | 405,071,600.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 413,935,100.00 | 389,741,980.04 | 403,221,600.00 | 400,684,677.56 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 166,625,500.00 | 143,630,419.00 | 124,569,600.00 | 124,525,475.56 |
| 210101 | Үндсэн цалин | 152,369,500.00 | 130,838,528.00 | 113,667,100.00 | 113,622,975.56 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | | 10,902,500.00 | 10,902,500.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,256,000.00 | 12,791,891.00 | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,995,100.00 | 17,822,727.64 | 16,654,000.00 | 15,953,471.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,330,000.00 | 11,326,120.00 | 11,323,000.00 | 11,069,667.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,666,300.00 | 1,501,593.00 | 1,333,000.00 | 1,245,275.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,333,000.00 | 1,179,858.00 | 1,065,700.00 | 995,943.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 333,300.00 | 306,759.00 | 268,100.00 | 248,770.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,332,500.00 | 3,508,397.64 | 2,664,200.00 | 2,393,816.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,669,900.00 | 4,610,176.00 | 5,446,200.00 | 4,178,724.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 775,900.00 | 716,716.00 | 575,900.00 | 497,992.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,240,600.00 | 3,240,466.00 | 4,216,900.00 | 3,210,389.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 653,400.00 | 652,994.00 | 653,400.00 | 470,343.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,024,500.00 | 10,013,890.00 | 10,155,100.00 | 10,149,787.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,209,500.00 | 1,208,740.00 | 639,500.00 | 638,314.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,951,600.00 | 6,951,600.00 | 8,152,200.00 | 8,150,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,414,100.00 | 1,414,100.00 | 914,100.00 | 913,268.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 126,200.00 | 126,200.00 | 126,200.00 | 126,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 323,100.00 | 313,250.00 | 323,100.00 | 322,005.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 495,000.00 | 484,500.00 | 495,000.00 | 495,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 495,000.00 | 484,500.00 | 495,000.00 | 495,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,516,300.00 | 8,516,300.00 | 1,376,300.00 | 1,368,450.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,470,700.00 | 4,470,700.00 | 420,700.00 | 414,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,045,600.00 | 4,045,600.00 | 955,600.00 | 954,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,482,100.00 | 1,478,500.00 | 3,519,600.00 | 3,509,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,482,100.00 | 1,478,500.00 | 3,519,600.00 | 3,509,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 36,226,700.00 | 36,420,560.00 | 196,492,500.00 | 196,133,670.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,650,000.00 | 34,898,000.00 | 194,710,600.00 | 194,600,160.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 178,200.00 | 178,000.00 | 178,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,200.00 | 337,950.00 | 350,000.00 | 350,340.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158,400.00 | 140,610.00 | 302,000.00 | 126,370.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 66,000.00 | 150,000.00 | 54,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 801,900.00 | 800,000.00 | 801,900.00 | 801,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 165,900,000.00 | 166764908.00 | 44513300.00 | 44371100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 165,600,000.00 | 166,464,908.00 | 43,770,800.00 | 43,631,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 300,000.00 | 742,500.00 | 740,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | | 1500000.00 | 1500000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 413,935,100.00 | 416,322,600.00 | 404,371,600.00 | 405,071,600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 402,775,100.00 | 402,775,100.00 | 404,371,600.00 | 404,371,600.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 11,160,000.00 | 11,360,000.00 | | 700,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,160,000.00 | 11,360,000.00 | | 700,000.00 |

## 4.6 Аудит нэмэлт санхүүжилтийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | **2506960.00** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **2,435,500.00** | | **2,760,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,435,500.00** | | **2,760,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **2,435,500.00** | | **2,760,000.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | | | **60,000.00** |
| 210601 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | | | 60,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **248,000.00** | | **2,200,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 248,000.00 | | 2,200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **2,187,500.00** | | **500000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,187,500.00 | | 500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | 2,506,960.00 | 2,760,000.00 |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | 2,260,000.00 |
| **1310** | нэмэгдэл санхүүжилтийн орлого | | 2,187,500.00 | | |
| 131001 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | | | 500,000.00 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | 2,506,960.00 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | 2,506,960.00 | 2,006,960.00 |